

Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны 2016 оны 10-р сарын мэдээ

2016.10.24

Хуулийн хэрэгжилт хяналт шалгалт

Хархорин сумын ЗДТГ-тай хамтран Байгаль хамгаалах сарын аян зарлаж Хархорин сумын хяналтын постыг 24 цагаар ажиллуулан эргүүл, хяналт шалгалтын ажлыг тогтмол хийж байна.



Шалгалтаар Архангай аймгийн Хотонт сумын иргэн Л.Рагчаа нь зохих эрхийн бичиггүй түлээний мод тээвэрлэж явсныг шалгаж сум дундын Ой ангиар экологи эдийн засгийн үнэлгээ гаргуулж ажиллаа.

Байгалийн нөөц хамгаалал



2016 оны 10 сарын 12 өдөр Дугаар 02

Орчны бүсийн менежментийн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.3 заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус сумын орчны бусад 2016-2020 онд хэрэгжүүлэх Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.
2. Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сайтар хэрэгжүүлэн ажиллахыг Орчны бүсийн зөвлөлийн дарга /М.Жамъяншарав/-т үүрэг болгосугай.

ДАРГА
М.ЖАМЬЯНШАРАВ

My Dok D-A-4 togtool /ЛТКН/

ТХНУГ-аас ирүүлсэн цаг хүндэрсэн үед зүүн аймгуудын мал оторлуулах тухай мэдээллийг 2016.10.05 өдрийн №72 тоотой хариу хүргүүллээ.

Бат-Өлзий сумын Орчны бүсийн Менежментийн төлөвлөгөөг боловсруулан сумын ИТХ-аар батлууллаа. Энэхүү төлөвлөгөө нь Бат-Өлзий сумын, 4-р багийн нутаг дэвсгэрт хэрэгжих бөгөөд тус багийн ИНХ, Багийн засаг даргын ирэх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуусан бөгөөд цаашид Германы БОЯБ-УАӨДЗ төслөөс хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллах юм.

Байгалын дагалт баялаг ашигласны эрхийн бичгийг 09 сарын 10 аас иргэдэд ахуйн зориулалтаар ТХГН-т олгох ажлыг зохион байгуулснаар одоогийн байдлаар нийт 200 бичиг олгож орон нутгийн төсөвт 2,5 сая төгрөг төвлөрүүлээд байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 63-р зарлигийн дагуу бүх нийтээр мод тарих өдрийг Хархорин сумын Засаг даргын тамгын газраас зохион байгууллаа. Энэ өдрөөр "Тод ундарга"ХХК-ны 250сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар захын хажууд барьж гүйцэтгэсэн цэцэрлэгт хүрээлэнгийн талбайд албан хаагчдыг оролцуулан 1050 ширхэг хайлаас модны суулгацыг тарьлаа.

Мод ургуулах хөдөлгөөнд ОХБЦГХЗахиргаа, Хас банк, Соёлын төв, Цагдаагийн хэлтэс, сум дундын Прокурорын газар, Сум дундын шүүх, Нийгмийн даатгалын тасаг, Нэгдсэн

эмнэлэг, “Орхон цогцолбор” ЕБС, БЭХ хоршоо, 1,2,3,4,5-р цэцэрлэгүүд, ЭБЦДҮС”ТӨХК, ЭБЦТҮС”ТӨХК, ОБА-ны 45-ранги, ОХСГДӨХЗахиргаа, ШШГА, ГСЕБС, ЗДТГ зэрэг байгууллагуудын 400 орчим албан хаагчид оролцож мод тарьлаа. Хархорин сумын цэцэрлэгт хүрээлэнд Хамт олноороо 60 ширхэг хайлаас мод тарьлаа.



Хархорин сумын ЗДТГ-тай хамтран бүх нийтээр хог цэвэрлэх өдрийн хүрээнд Орхон голын отоглох цэгийн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэлээ.



Мэдээлэл, сургалт, сурталчилгаа



БОАЖЯ-ны Хяналт үнэлгээ дотоод аудитын газрын дарга Алтангэрэл 5 хүний бүрэлдэхүүнтэй манай хамгаалалтын захиргааны үйл ажиллагаатай танилцлаа.



БОАЖЯам, KFW-төслөөс хамтран “Монгол орны ТХГ-ын биологийн олон янз байдлын мониторингийг сайжруулах нь” сэдэвт сургалт, семинар Хустайн нурууны БЦГ-т 2016 оны 15-16-ны өдрүүдэд зохион байгуулсан ба уг сургалтанд хамгаалалтын захиргааны судалгааны мэргэжилтэн Ж.Пүрэв оролцлоо.

Мэдээ нэгтгэсэн: Мэргэжилтэн Ч.Суурьтогтох